ХАЛДВАРААС ХЭРХЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВЭ?

- Шаардлагагүй тарилга, хатгалтаас зайлсхийх
- Баталгаатай цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх
- Эмнэлгийн багаж хэрэгслийг стандартын дагуу ариутгаж, боломжтой бол 1 удаагийн багаж хэрэгсэл хэрэглэх
- Сахлын хутга, шүдний сойз, хумсны хутга зэрэг ахуйн эд зүйлсийг дамжуулан хэрэглэхгүй байх
- Бэлгийн тогтмол хавьтагчтай байх, хамгаалалтгүй бэлгийн харьцаанаас татгалзах
- Шивээс хийлгэх, арьс цоолох зэрэг арьс салстын бүрэн бүтэн байдлыг алдагдуулах ажилбараас татгалзах
- Эрсдэлтэй бүлгийн хүн ам*-ыг хепатитийн В вирүсийн эсрэг дархлаажуулалтанд хамруулах

* Үүнд: эмч эмнэлгийн ажилтануд, халдвартай эхээс төрж байгаа нярай, цус цусан бүтээгдэхүүн сэлбүүлдэг хүмүүс, эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүд, бэлгийн олон хавьтагчтай болон гоо сайхны мэс ажилбар хийлгэдэг хүмүүс гэх мэт

ДАРХЛААЖУУЛАЛТ

- Бага насны хүүхдүүд заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу дархлаажуулалтанд хамрагдана.
- Насанд хүрэгсэд сайн дурын үндсэн дээр хепатитийн В вирүсийн эсрэг вакцины 3 удаагийн тунг 6 сарын дотор хийлгэснээр амьдралынхаа туршид уг халдвараас өөрийгөө хамгаалах боломжтой.

Эхний тун → **1 сар** → **2 дах тун** → **5 сар** → **3 дах тун**

FIRE
Flagstaff International Relief Effort

ЖИЛ БҮРИЙН 7 САРЫН 28-НЫ ӨДӨР

Хепатитийн вирүсийн халдварыг эрт оношлуулж эмчлүүлсэнээр та өвчний хүндрэлээс сэргийлж, өөрийн хайртай хүмүүсээ хамгаалах боломжтой.

ХЕПАТИТИЙН В ВИРҮСИЙН ХАЛДВАР



www.fireprojects.org



ХЕПАТИТИЙН В ВИРҮСИЙН ТАЛААР

- Хепатитийн В вирүсийн халдвар нь элгийг сонгомлоор гэмтээж, улмаар элэгний хатуурал, элэгний хавдарт шилжих эрсдэлтэй эмгэг юм.
- Манай орон хепатитийн В вирүсийн халдвар нутагшмалаар өндөр тархсан орны тоонд багтдаг.

Та хэдийгээр халдвар авсан ч танд шинж тэмдэг, зовиур илрэхгүй эрүүл мэт харагдаж болно.

Ихэнх тохиолдолд энэ өвчний үед ямар нэг шинж тэмдэг илэрдэггүй тул хүмүүс халдвар авснаа мэдэлгүйгээр бусдад халдвар тараах эрсдэлтэй байдаг.

- Ядарч сульдах
- Арьс салст шарлах
- Хоолны дур, шингэц муудах
- Гэдэс дүүрэх, цанхайх
- Аюулхай, баруун хавирганы нуман доогуур тулж хатуулдах
- Шээсний өнгө өөрчлөгдөж өтгөн хар цай шиг болох зэрэг шинж тэмдгүүд илэрнэ.

ХАЛДВАР ДАМЖИХ ЗАМУУД

1. Цусаар

- Халдвартай цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх
- Халдвартай хүний цус болон биологийн шингэнээр бохирлогдсон зүү тариур, эмнэлгийн багаж хэрэгсэл
- Сахлын хутга, шүдний сойз, хумсны хутга гэх мэт ахуйн хэрэгслийг дамжуулан хэрэглэх
- Арьс цоолох, шивээс хийх зэрэг гоо сайхны ажилбарын багаж хэрэгслийг дутуу ариутгах, дахин хэрэглэх

2. Бэлгийн замаар

- Халдвартай хүнтэй хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох

3. Эхээс хүүхдэд

- Халдвартай эхээс хүүхэд төрөх үед халдвар дамжих боломжтой.

ХАЛДВАР ДАМЖИХГҮЙ ЗАМУУД

- Ханиаж найтаах
- Тэврэх, үнсэх
- Хоол хүнс, аяга тавгаа дундаа хэрэглэх
- Ахуйн хавьтал
- Хөхөөр хооллох зэргээр халдвар дамжихгүй

Хепатитийн В вирүсийн халдвартай байна гэдэг нь ичгэвтэр хэрэг бус гэдгийг сана. Халдвартай хүмүүс бусдын л адил эрхээ эдэлж, амьдрах эрхтэй.

ХЭРВЭЭ ТА ХЕПАТИТИЙН В ВИРҮСИЙН ХАЛДВАРТАЙ БОЛ

- **Тогтмол шинжилгээ өгөх**

Хепатитийн В вирүсийн халдвар зарим тохиолдолд архагших, вирүс тээгч болох, алсдаа элэгний хатуурал, хавдрын урьтал шалтгаан болж болзошгүй.
Хэдийгээр танд өвчний шинж тэмдэг, зовиур илрэхгүй байсан ч дараах шинжилгээг тогтмол өгч байгаарай.

Хугацаа	Шинжилгээ	Оношилгооны ач холбогдол
6 сар тутам	Цусанд АЛАТ, АСАТ үзэх	Элэгний эсийн гэмтэл
	Цусанд Альфа фетопротейн /AFP/ үзэх	Элэгний хавдар
Жилдээ*	Элэгний хэт авиан оношилгоо	Элэгний бүтцийн өөрчлөлт

* Таны гэр бүлийнхний хэн нэг нь элэгний хавдраар өвчилж байсан бол та энэ шинжилгээг 6 сар тутам өгөөрэй.

- **Эмчийн хяналтанд байх**
- **Зөв зохистой хооллох, амьдралын хэв маягаа өөрчлөх**
- **Архи, согтуурулах ундаанаас татгалзах**
- **Гэр бүлийн гишүүд, өөрийн хайртай хүмүүсээ хамгаалах**

Хэрвээ таны гэр бүлийн гишүүд, бэлгийн хамтрагч тань хепатитийн В вирүсийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, халдваргүй нь батлагдсан бол сайн дурын дархлаажуулалтанд хамруулаарай.

- **Хепатитийн D вирүсийн давхар халдварт өртөхөөс сэргийлэх**